

**Үндэсний бөхийн 2021 оны өсвөр үеийн аймгийн
АВАРГА ШАЛГАРУУЛАХ АВАРГЫН ГАРАА ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ**

2021.11.01

Нэг.Тэмцээний зорилго

Архангай аймгаас төрөн гарсан алдарт бөхчүүдийн залгамж халааг бэлтгэх, ахмад үеийхнийг алдаршуулах, тэдний туршлагыг залуу хойч үедээ өвлүүлэн, барилдааны явцад ёс зүйн алдаа дутагдал гаргавал зөв дадал арга барилыг олгох, барилдах авъяасыг нээн илрүүлэх, үндэсний өв соёлыг түгээн дэлгэрүүлэхэд оршино

Хоёр.Хамрах хүрээ

Архангай аймгийн ерөнхий боловсролын сургуулийн болон үндэсний бөхөөр хичээллэдэг өсвөрийн тамирчид, сурагчид 16,17,18 насны ангилалаар зохион байгуулах бөгөөд 16 нас хүрч, иргэний үнэмлэх авсан хөвгүүд оролцоно.

Тэмцээний **16 насанд** :2004.11.01-нээс 2005.11.1 ний хооронд төрсөн хөвгүүд

17 насанд 2003.11.01 нээс 2004.11.01 ний хооронд төрсөн хөвгүүд

18 насанд 2002.11.01 нээс 2003.11.01 ний хооронд төрсөн хөвгүүд тус тус барилдана

Гурав.Барилдаан зохион явуулах аргачлал

Барилдаан тойргийн журмаар явагдаж дүнг гаргана. Багийн дүнг гаргахдаа бага онооны системийг хэрэглэнэ.Хэрвээ энэ үзүүлэлт ижил гарвал дараах үзүүлтүүдийг ээлж дараалан харгалзах журмаар зохих байрыг тодорүүлна. Үүнд :

-Гурван бөхийн давааны тоо

-Эзэлсэн байрны чанар

-Хамгийн бага насанд эзэлсэн байрыг тус тус харгалзана.

Харин аль нэг насанд бөх оруулаагүй бол тэр багт /насанд/ хамгийн их оноог өгч байрыг эзлүүлнэ.

Дөрөв.Техникийн зөвлөлгөөн /мандат олгох/

Тэмцээний техникийн зөвлөлгөөн 2021 оны 11 дүгээр сарын 04ны 14 цагт биеийн тамир спортын газар явагдана.Бүртгэл 14.00-18.00 цаг хүртэл явагдана.Техникийн зөвлөлгөөнд ирэхдээ тамирчдын бичиг баримт багийн мэдүүлэгийн хамт авчирна.